



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 109

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд шаардлагатай нийт 38,000,000 /гучин найман сая/ төгрөгийн үнэтэй үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга (Г.Зоригт)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



11-
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын
23 өдрийн 109 тогтоолын нэгдүгээр хавсралт

Санхүүгийн хяналт, аудитын албаны шинээр
бэлтгэсэн хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар					
1	Delica D5 автомашин	ш	1	33,000,000	33,000,000
Төсвийн хөрөнгөөр					
2	Оффис сандал	ш	2	250,000	500,000
3	Делл процессор	ш	3	1,220,000	3,660,000
4	Делл дэлгэц	ш	3	280,000	840,000
	Нийт дүн				38,000,000 /гучин найман сая/